

2026 он 4 сар 28 өдөр

Дугаар 01/26

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*2025 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2026 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ОДБАЯР

2026 он 4 сар 28 өдөр

Дугаар 02/26

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
 гишүүдийг сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 2026 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №3 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Одончимэд овогтой Одбаяр, Галням овогтой Уянга, Галбадрах овогтой Цогбадрах, Мөнхбат овогтой Мөнх-Эрдэнэ, Намдалдагва овогтой Эрдэнэтулга, Сүхдорж овогтой Оргил нарыг, хараат бус гишүүнээр Баатарзоригт овогтой Болорчимэг, Ганхуяг овогтой Хонгорзул, Нанзад овогтой Хосбаяр нарыг тус тус сонгохыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Баярбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ОДБАЯР

2026 он 4 сар 28 өдөр

Дугаар 08/26

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн дүрэм нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь хэсэг, 2026 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №4 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.4-д “Компани “Хүчтэй.Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал since 1994 гэж бичсэн байна” гэж заасныг “Компани “Хүчтэй.Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь Ard гэсэн гурван үсгээс бүрдсэн хар болон цагаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал ХК гэж бичсэн байна” гэж өөрчилсүгэй.
2. Энэхүү шийдвэрийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ОДБАЯР

2026 он 4 сар 28 өдөр

Дугаар 04/26

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн хувьцаа эргүүлэн худалдаж авч
хувьцаа халааслах шийдвэр гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь хэсэг, 2026 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №5 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн гаргасан энгийн хувьцааны 15 хувь буюу 3,750,000 ширхэг хүртэл хувьцааг эргүүлэн худалдан авч дараах нөхцөлтэйгээр халааслахаар шийдвэрлэсүгэй.

Эргүүлэн худалдаж авах тоо	3,750,000 ширхэг хүртэл (15 хувь хүртэл)
Эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнэ	800 төгрөг хүртэл
Эргүүлэн худалдаж авах хугацаа	12 сар
Эргүүлэн худалдаж авах нийт дүн	3,000,000,000 тэрбум төгрөг хүртэл

2. Хувьцаа эргүүлэн худалдан авч халааслах хөтөлбөрийг Хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хувьцаа эргүүлэн худалдаж авах ажлыг гүйцэтгэх, зохицуулагч байгууллагаас зохих зөвшөөрөл авах, харилцах зэрэг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтүлга)-д даалгасугай

ХУРЛЫН ДАРГА



О.ОДБАЯР